



БАТЛАВ.  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА

Ч.МОНХТУЯА

2024 оны 11 дугаар сарын 15 – ны өдөр

БУЯНТ-УХАА ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ НИСЛЭГИЙН ХӨДӨЛӨГӨӨНИЙ  
УДИРДЛАГЫН ЦАМХАГИЙН ЦОНХНЫ ГЭРЭЛ БУУРУУЛАГЧ ХАЛЬС СОЛИХ  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолт нь Буянт-Ухаа цамхгийн ажлын байрны албан хэрэгцээнд шаардлагатай гэрэл бууруулагч хальсыг нийлүүлж суурилуулах ажлын шаардлага болон тоо хэмжээг тусгасан болно.


2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 2.1 Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн шинэ байна.
- 2.2 Техникийн тодорхойлолтод тусгасан бараа нь үйлдвэрийн чанарын шаардлага хангасан байна.
- 2.3 Нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгааны бичиг ирүүлнэ.
- 2.4 Барааны үзүүлэлтийг харуулсан баримт бичгийг Монгол эсхүл Англи хэл дээр ирүүлнэ.
- 2.5 Барааны өнгө, загварын талаар захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр нийлүүлнэ. Сонголтуудтай фото зураг, танилцуулга ирүүлнэ.

3. БАРААНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ТОО ХЭМЖЭЭ

Д/Д	Барааны нэр, төрөл	Барааны үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1. Консолын гэрэл					
1.1	Нислэгийн удирдагчийн ажлын байрны цамхагын гэрэл бууруулагч хальс	<ul style="list-style-type: none"><li>Улиралын шинж чанартай хэт халалт болон нарны хурц гэрэл бууруулж гялбалтаас бүрэн хамгаалдаг байх,</li><li>70-80% гэрэл бууруулах чадамжтай байна.</li><li>Байрлуулах өнцгөөс үл хамааран гадна орчин болон агаарын хөлөг буух хөөрөх үед харагдцад нөлөөлдөггүй байх,</li><li>Ажлын байрны таазнаас суурилуулах боломжтой байх,</li><li>Уян хатан хурааж гаргадаг дамартай байх /roller screen/</li></ul>	Ш	11	Цамхгийн ажлын байрны 11 цонхонд суурьлуулах

**БУЯНТ-УХАА ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ НИСЛЭГИЙН ХӨДӨЛӨГӨӨНИЙ  
УДИРДЛАГЫН ЦАМХАГИЙН ЦОНХНЫ ГЭРЭЛ БУУРУУЛАГЧ ХАЛЬСНЫ ХЭМЖЭЭ  
/САНТИМЕТРЭЭР/**



#### **4. БУСАД НӨХЦӨЛ**

- 4.1 Ажлын шаардлага хангасан, чанарын гологдолгүй байна.
- 4.2 Барааны үзүүлэлт, тоо хэмжээ хавсралтад заасан тоо хэмжээтэй нийцэх ба чанарын шаардлага хангасан байх.

#### **5. ХҮЛЭЭН АВАХ**

- 5.1 Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан барааг нийлүүлнэ.
- 5.2 Нийлүүлэгч тал барааг тээвэрлэх, зөөхдөө бүрэн бүтэн байдлыг хариуцаж, заасан байрлалд угсарч сууринуулж өгнө.
- 5.3 ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр бараа болон ажил үйлчилгээг хүлээн авсанд тооцно.

5.4 Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.

5.5 Ачааг хүргэх цэг: ИНҮТ, ХУД, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар, Монгол улс

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Барилга байгууламжийн ашиглалтын  
албаны дарга;

Ч.Болдсүрэн

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн;

Э.Уянга

“ХУД Яармаг” Төрийн бус  
байгууллагын гишүүн;  
(тохиролцсоноор);

О.Бат-Амгалан